



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 19

Хараат

Сумын 2022 оны газар зохион байгуулалтын
төлөвлөгөө батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18дугаар зүйлийн 18.1.2, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтуудыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 5 дугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
2. Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, журмын дагуу газрыг өмчлүүлж, эзэмшүүлэх ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга (Д.Буджав)-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга (Ч. Бямбасүрэн)-д даалгасугай.

ХУРАЛ УДИРДСАН



Н.ОЮУНЦЭЦЭГ



2022 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Хэрэгжүүлэх арга зам	Хариуцах эзэн	Хугацаа
1. Хууль тогтоомж сурталчлах, сургалт семинар зохион байгуулах иргэд, хуулийн этгээдэд мэдээллээр үйлчлэх			
1.1	Газрын харилцааны талаар болон газар эзэмшил, өмчлөлийн талаар хөдөөгийн малчдад мэдээлэл хийх	Газрын даамал	Улирал бүр
2. Газрын нөөцийг төлөвлөх, зурагжуулах, эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах ажлыг зохион байгуулах талаар			
2.1	Сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ИТХ-аар батлуулах	СЗД, ГД	2021.12.17
2.2	Газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах 6 иргэнд 0.52 га газрыг өмчлүүлэх, мэдээллийн санд бүртгэх	СЗД Газрын даамал	Жилдээ
2.3	Сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнд болон байгууллагуудын эзэмшил газрын ногоон байгууламжинд мод, бут нэмж тарих сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнөөс ойн зурвас байгуулах 202 га, Мод үржүүлгийн газрын 1 га	СЗД, БОУБ	Жилдээ
2.4	Суманд үйлдвэр үйлчилгээний зориулалттай газрыг дараах байршилд олгох: <ul style="list-style-type: none"> Уурын зуухны хажууд Ембүү 223 600м² гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар Ембүү 207 тоот 650м² гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар Ембүү 209 тоот 734м² гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар Ембүү 219 тоот 895м² гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 16 зөрлөг 50 га тэжээлийн ургамал усалгаатай газар тариалан Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан Худалдаа үйлчилгээний зориулалттай 300м² Цэцэнс майнинг ХХК хамгаалалтын 32 км зурвас тогтоох Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан Тариалангийн газар 150га / Багийн төв барих 700м² Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан Мал нядлах газар 900 м² 	СЗД, Газрын даамал	Жилдээ
3. Бэлчээр зохион байгуулалтын арга хэмжээний талаар			
3.1	Өвөлжөө хаваржааны доорхи газрыг 14 өрхөд 7 га газрыг эзэмшүүлж, мэдээллийн санд бүртгэх, Э дугаарыг олгох	СЗД, Газрын даамал	Жилдээ
3.2	ОНХСангаар багт энгийн уурхайн худаг сэргээн засварлах, гүн өрмийн худаг шинээр гаргах	СЗД, БЗД, Газрын даамал	Жилдээ
3.3	Бэлчээр мониторингийг хийж мэдээллийн санд оруулах, сумын хэмжээнд бэлчээр, хадлангийн төлөв байдлын	Газрын даамал	Жилдээ

	үнэлгээг хийж, бэлчээрийн даацын хүрэлцээ, ургамлын гарцын талаар дүгнэлт гаргах	УЦУОШГ, БОУБ	
3.4	Бэлчээрийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх ажил зохион байгуулах	БЗД, БОУБ,ХААТ	Жилдээ

**ЦАГААНДЭЛГЭР СУМЫН 2022 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэл	Төлөвлөж буй хэмжээ /га/
1	Хот суурин газар бүгд	га		
	Шинээр байгуулагдах суурин газар болон суурьшлын бүс	га		
	Эзэмшүүлэх газар	га		7
	Өмчлүүлэх газар	га		0.52
	Ашиглуулах газар	га		
	Уул уурхайн ашиглалтын талбай	га		
	Шинээр шугам сүлжээнд холбогдох газар /эрчим хүч, харилцаа холбоо/	км		32 км
2	Шинээр инженерийн байгууламжаар хангагдах газар /ус суваг, дулаан г.м/	га		
	Зам шугам сүлжээний газар – бүгд	га		
3	Орон нутгийн чанартай зам	га		
	ХАА-н газар – бүгд	га		
3.1	Тариалангийн газар	га		150га
3.2	Бэлчээрийн талбай – бүгд	га		
	Үүнээс МАА-д ашиглагдах бэлчээр	га		
	Малын тоо /хонин толгойд шилжүүлсэнээр/	толгой		
	Нэг хонин толгойд ноогдвол зохих бэлчээр	га		
	Бэлчээрийн даацын хүрэлцээ, хангамж	га		
	Хашиж хамгаалах бэлчээр	га		16
	Шинээр байгуулах, болон засварлах утс цэг, усан сан, хөв далангийн тоо	Тоо ширхэг		5
	Хайгуулын лицензид хамрагдсан талбай	га		
4	Усан сан бүхий газар – бүгд	га		
	Хашиж хамгаалах булаг шанд, рашаан бүхий газрын талбай	га		
	Тусгай хэрэгцээний газар – бүгд	га		
	Улсын ТХГН	га		
	Орон нутгийн ТХГ	га		